



XANADU MINES

Тогтвортой байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

ASX:XAM | TSX:XAM
xanadumines.com



Хэтийг харсан мэдэгдэл

Энэхүү баримт бичиг нь компаниас хийсэн олон жилийн туршлага болон дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан хэтийн төлөвийн мэдэгдэл юм. Энэхүү баримт бичигт дурдсан ирээдүйг харсан мэдэгдэл нь таамаглахад хэцүү, компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй (томоохон, гол) эрсдэл, тодорхой бус байдал болон таамаглалыг агуулсан болно. Түүнчлэн ирээдүйн техник, эдийн засаг, зах зээл, улс төр, нийгмийн болон бусад нөхцөл байдалтай холбоотой таамаглал болон тооцоололд үндэслэн ашигт малтмалын ордын баялаг ба нөөцийн урьдчилсан тооцоолол, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэл, үйлдвэрлэл ба үнэ, нөхөн сэргээх зардал болон үр дүн, капитал зарцуулалт зэргийг багтаан оруулсан болно. Эдгээр мэдэгдэл нь тодорхой тооцоолол ба таамаглалд үндэслэсэн бөгөөд Занаду Майнз компанийн судалгаагаар үндэслэлтэй гэж үзсэн хэдий ч техник, бизнес, эдийн засаг, зах зээлийн өрсөлдөөн, улс төр болон нийгмийн тодорхой бус байдалд өртөж болох тул мэдэгдэлд тусгагдсан ирээдүйд тооцоолсон болон таамагласан үйл явдлууд бодит үйл явдлаас ихээхэн ялгаатай байж болзошгүй. “Итгэх”, “хүлээх” (аливааг тийм болох байх гэж таамаглах, бодох санах гэсэн утгаар), “урьдчилан таамаглах”, “онцгойлох”, “тунгаан бодох”, “зорих”, “төлөвлөх”, “үргэлжлүүлэх”, “төсөвлөх”, “тооцоолох”, “магадгүй”, “ирээдүйд”, “хуваарилан төлөвлөх” гэх мэт үгс нь энэхүү мэдэгдлийг тодорхойлно (товчоор хэлбэл, эдгээр үг хэллэг энэхүү мэдэгдэлд олонтаа давтагдана гэж ойлгож болох юм). Энэхүү тайланд тусгагдсан хэтийн мэдэгдлийг тайлан боловсруулах үеийн мэдээ мэдээлэлд тулгуурлаж хийсэн бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд компани ирээдүйд үүсч болох шинэ үйл явдал, нөхцөл байдалтай холбоотойгоор хэтийн мэдэгдлийг шинэчлэх эсвэл засварлах үүрэг хариуцлагыг хүлээхгүй.

Энэ тайланд тусгагдсан бүхий л жил нь хуанлийн тоололд хамаарна.



АГУУЛГА

Тайлангийн тухай	4
ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Үйл ажиллагаа хариуцсан захирлын мэндчилгээ	8
Занаду Майнз компанийн тухай	9
Компанийн тухай	9
Үнэт зүйлс	10
Төслүүд	10
Ажлын гүйцэтгэлийн хураангуй	12
Тогтвортой байдлын талаар баримтлах хандлага	13
Бодит байдал	14
Оролцогч талуудын оролцоо	15
Байгаль орчин	16
Уур амьсгалын өөрчлөлт	17
Байгаль орчны менежмент	19
Газар болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн удирдлага	19
Усны менежмент	20
Бодит жишээ – Бохир ус цэвэрлэх - Септик систем	21
Хамт олон	22
Эрүүл мэнд, аюулгүй байдал	23
Бодит жишээ – Дээж боловсруулах байгууламж	24
Орон нутаг	25
Хамтын ажиллагаа	26
Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт	26
Бодит жишээ – Орон нутгийн цэцэрлэг	29
Хариуцлагатай бизнес	30
Бизнесийн ёс зүй ба Ил тод байдал	31
Хавсралт 1: Глобаль Тайлагналын Санаачлагын Индекс	34
Хавсралт 2: Олон улсын уул уурхай, металлын зөвлөлийн (ICMM) Уул уурхайн 10 зарчим	41

ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

Энэхүү тогтвортой байдлын тайлан нь Занаду Майнз Лимитед компанийн 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) удирдлага болон гүйцэтгэлийн талаарх мэдээллийг компанийн санхүүгийн тайлагналын хугацаатай нийцүүлэн тайлагнасан болно.


Занаду компанийн жилийн тайлан, Компанийн засаглалын мэдэгдэл, Хавсралт 4G болон ТУЗ-ийн дүрэм ба Компанийн бодлого болон Тогтвортой байдлын тайланг xanadumines.com/corporate-governance вэб сайт дээр олон нийтэд нээлттэй байршуулсан.

Энэхүү тайланг Тайлагналын Олон улсын Санаачилга (2021) (GRI) стандарт болон Олон улсын Уул Уурхай, Металлын Зөвлөлийн (ОУУУМЗ) олборлолтын 10 зарчмын дагуу бэлтгэсэн. Тайлангийн тодруулгуудыг Занаду Майнз Лимитед компанийн ТУЗ хянаж, баталгаажуулсан болно.

Санал хүсэлт ба асуулт

Энэхүү тайлантай холбоотой санал хүсэлтийг ТУЗ-ийн дарга ба Гүйцэтгэх захиралд хаяглаж болох ба тэрээр Гүйцэтгэх удирдлагын багтай хамтран хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудын асуултад хариулна.

Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талууд Занаду Майнз компанитай +61 2 8280 7497 утас болон info@xanadumines.com цахим хаягаар холбогдох боломжтой.







ТУЗ-ИЙН ДАРГА БОЛОН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хувьцаа эзэмшигч танаа,

Тогтвортой байдал болоод байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын гол хэмжүүрүүдэд үндэслэсэн компанийнхаа гүйцэтгэлийг онцлон харуулах “Тогтвортой байдлын тайлан”-гийн 2023 оны хувилбарыг Занаду Майнз компанийн нэрийн өмнөөс танилцуулж байгаадаа таатай байна.

Компаниас гаргаж буй 4 дэх удаагийн “Тогтвортой байдлын тайлан”-даа Занаду Майнз компани нь “Монгол улсад ил тод, хариуцлагатай ашигт малтмал хайгуулын компани байх, тогтвортой хөгжлийг бий болгох нь бидний шийдвэр гаргах үйл явцын тэргүүнд байх ёстой”- гэдгийг онцлон тусгасан.

Дэлхий ертөнц эрчим хүчний нарийн төвөгтэй, тодорхойгүй шилжилтийн үе шатанд ирж байгаа бөгөөд зэс нь сэргээгдэх эрчим хүч болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх мөн энэхүү шилжилтэд хувь нэмэр оруулах чухал металл юм. Үүнтэй зэрэгцэн эрчим хүчний шилжилтийн улмаас

зэсийн эрэлт өсч, нийлүүлэлт тасралтгүй буурч байгаа нь зэсийн зах зээл бүтцийн хомсдолд ороход хүргэж байгаа юм.

Занаду Майнз компанийн Хармагтай төслийн бүтээн байгуулалт нь энэхүү эрчим хүчний шилжилтэд хувь нэмэр оруулах онцгой боломжийг бий болгож байна. Мөн Хармагтайн ордын төслийг орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, стандартад нийцүүлэн боловсруулсан тул уул уурхайн салбар дахь эрчим хүчний хамтын шийдлийн нэг хэсэг болж чадахын тод жишээ болж байна.

Бидний алсын хараа нь оролцогч талуудад үр өгөөжтэй орчин үеийн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай зэсийн уурхайг бий болгохын сацуу сэргээгдэх эрчим хүч, цахилгаан тээврийн хэрэгсэл, эрчим хүчний эрчимжилтийг бууруулсан үйлдвэрлэл ба ялгаруулалт багатай олборлолтын арга хэрэгслийн судалгаа зэргийг багтааж урьдчилсан ТЭЗҮ-ээр дамжуулан алсын харааны зорилтоо хэрэгжүүлэхийг зорьж байна.

Хармагтай төслийн туршлага дээр тулгуурлан оролцогч талуудын нэрийн



Бид цаашдын бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой байдлын зорилгод нийцэх эсэхийг баталгаажуулах зорилгоор Тогтвортой байдлын бодлогоо шинэчилсэн.

-Колин Мурхед, ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал

өмнөөс төслийн хүрээгээ өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө ажиллахын сацуу тогтвортой хайгуул болон бүтээн байгуулалтын ижил зарчмуудыг шинэ төслүүддээ хэрэгжүүлэх болно.

2023 онд Занаду Майнз компани бизнесийн үйл ажиллагаандаа тогтвортой байдлыг нэвтрүүлэхдээ Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог боловсруулан ажиллаж байна. Энэхүү БОНЗ-ын цар хүрээ нь оролцогч талуудад хамгийн чухал гэж тодорхойлсон тогтвортой байдлын найман зорилтыг Байгаль орчин, Хүмүүс, Олон нийт, Хариуцлагатай бизнес гэсэн дөрвөн тулгуурт нэгтгэсэн болно.

Хоёрдугаарт, манай компанийн бизнесийн үйл ажиллагаа тогтвортой байдлын зорилгод нийцэж буй эсэхийг баталгаажуулахын тулд Тогтвортой байдлын бодлогоо хянаж, шинэчилсэн.

Занаду Майнз компани нь Монгол улсын уул уурхайн салбарын ирээдүйд итгэл, найдвар тавьсан хэвээр байна. Монгол улс бол тогтвортой, ардчилсан засгийн газартай, уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэх эрмэлзэлтэй, дэлхийн зэсийн зах зээл дээр хамгийн том хэрэглэгч болох

Хятад улстай хөрш зэргэлдээ оршдог улс юм.

Биднийг үргэлж дэмжиж ирсэн оролцогч талууддаа талархлаа илэрхийлж, бидний аялалын дараагийн үе шатанд тогтвортой үнэ цэн бий болгохыг тэсэн ядан хүлээж байна.



Колин Мурхед,
ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал

ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон энэ жил нь Занаду Майнз компанийн хувьд Монгол улсад тогтвортой байдлын туршлагаа үргэлжлүүлэн хөгжүүлсэн маш завгүй жил болж өнгөрлөө.

Бид Өмнөговь аймгийн Хармагтай төсөлд БОНЗ-ын тогтолцоог хэрэгжүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гаргасан жил байлаа. 2023 онд гаргасан бидний амжилтаас дурдвал:

1. Хармагтай төслийг Монгол улсын өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээнд холбосон. Энэ нь дизель түлшээр гаргадаг цахилгаан эрчим хүчнээс хараат байдлыг бууруулж, орон нутгийн замд дизель түлшний тээвэрлэлтийг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах юм. Мөн тухайн төслийн талбайд судалгаа шинжилгээ хийх, Хармагтай олборлолтод шилжсэний дараа барилга угсралтын ажилд илүү найдвартай цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болох боломжийг олгосон юм.
2. Бид ажилтнуудаа эрүүл аюулгүй ажлын байраар хангахыг эрхэмлэж, дээж боловсруулалтын шинэ байгууламжийг барьсан, ажилчдын амрах шинэ байрыг ашиглалтад оруулж, ажилтнуудаа шинэхэн жимс, хүнсний ногоогоор хангахын тулд шинэ хүлэмжийг барьсан зэрэг хэд хэдэн томоохон ажлуудыг хийгээд байна. Компани хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилтны эрүүл мэндийг нэн тэргүүнд тавьж ажилладаг бөгөөд 2023 оны байдлаар сүүлийн 4 жилд Хугацаа алдсан гэмтлийн давтамжгүй ажилласныг дуулгахад таатай байна.

3. Олон нийтийг тасралтгүй дэмжиж ажилладаг. Боловсрол, жижиг дунд бизнесийг хөгжүүлж, усан хангамж болон нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллаж чадсан. Хамгийн онцлох хөтөлбөр бол Өмнөговь аймгийн Засаг даргын талархлыг хүлээж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан STAR хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрт орон нутгийн цэцэрлэгийн анги танхимыг тохижуулж, засварлах ажил багтсан бөгөөд 2024 онд үргэлжлүүлэн хийх төсөл юм.

4. БОНЗ-ын тогтолцоог хэрэгжүүлсэн. Энэхүү тогтолцоо нь сэргээгдэх эрчим хүчний чухал бүрэлдэхүүн хэсэг болох уурхай, үйлдвэрүүдийн эрчим хүчний хангамжийн талаарх сүүлийн үеийн судалгаа болон говь цөлийн эмзэг экологийн орчинд усан хамгамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Хармагтайн урьдчилсан ТЭЗҮ-ийн техникийн судалгааг санхүүжүүлэхэд анхаарал хандуулсан нь Тогтвортой байдлын зорилгодоо хурдан хугацаанд хүрэх боломжийг бидэнд олгосон юм. Цаашид ч үргэлжлэх бөгөөд ингэснээр дэлхийн жишигт нийцсэн БОНЗ-тай маш том хэмжээний олборлолтын үйл ажиллагааны суурийг тавьж байгаа юм.

Мөнхсайхан Дамбийням

Үйл ажиллагаа хариуцсан захирал



ЗАНАДУ МАЙНЗ КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай

Занаду Майнз компани нь дэлхийн түвшний порфирийн төрлийн зэс-алтны ордуудыг нээн илрүүлж, хөгжүүлдэг хайгуул, хөгжүүлэлтийн компани юм. Манай компани олон шатлалт төслүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд нэрийн хуудас болсон төсөл нь Хармагтайн зэс-алтны төсөл юм.

Биднийг дараах байдлаар тодорхойлж болно.

- Олон жилийн туршлагатай, хайгуулын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Австрали мөн Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани
- “Зижинь Майнинг” групптэй хамтран санхүүжүүлсэн, урьдчилсан ТЭЗҮ-ийн шатанд буй порфирийн төрлийн зэс-алтны Хармагтай төслийг хэрэгжүүлж байна
- Монгол улсад үнэт болон суурь металын хайгуулын төслүүдийг эзэмшиж байгаа
- Төв Азийн ороген бүслүүр дэх чанартай төслүүдийг үнэлэх бүрэн эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж буй компани юм.

Бид Монгол улс дахь байр сууриа стратегийн давуу тал гэж үздэг учир нь:

- **Хэтийн төлөв** - Дэлхийн хэмжээний ач холбогдолтой нээлт бүхий ордуудтай бөгөөд харьцангуй бага судлагдсан
- **Хөгжүүлэх боломж** - Цөөхөн хүн амтай, маш сайн дэд бүтэцтэй өргөн уудам нутагтай (ялангуяа Өмнөд говьд)

- **Уул уурхайн соёл** - Тогтвортой ардчилалтай, боловсрол, сургалтын өндөр стандарттай, уул уурхайн салбар нь ДНБ-ий 25% болон экспортын 90%-ийг бүрдүүлдэг
- **Байршил** - Одоогийн болон цаашид төлөвлөгдсөн маш сайн дэд бүтэцтэй, Хятад улстай (Дэлхийн зэсийн зах зээлийн №1 хэрэглэгч) хил залгаа
- **Орон нутгийн ноу-хау** - Занаду Майнз нь геологийн талаар гүнзгий мэдлэг, туршлагатай бөгөөд Монгол улсад БОНЗ-ын стандартын дагуу өндөр түвшинд ажиллах чадвартайгаа харуулсан.

Занаду Майнз компанийг порфирын төрлийн зэс-алтны уурхайг нээн илрүүлж, амжилттай хөгжүүлсэн хайгуул болон олборлолтын туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдсэн баг удирддаг.

Занаду нь түншүүдийнхээ хамтаар төсөл бүрийг хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад хамтын үнэ цэнийг бий болгохын төлөө удирдан ажиллаж байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Занаду Майнз компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан үнэт зүйлсийг веб хуудаснаас харах боломжтой. Манай компанийн үнэт зүйлс нь Занаду Майнз компанийн бий болгохыг зорьж буй байгууллага ямар болохыг тодорхойлдог, түүнд хүрэхэд ТҮЗ-ийнхөн захирлууд, гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудаас хүлээж байгаа үр дүнг тодорхойлох үндсэн зарчим, хэм хэмжээнүүд юм.

Бидний баримталдаг таван үнэт зүйлс:

1. Тогтвортой байдал

Бид Монгол дахь түншүүддээ хариуцлагатай компанийн иргэн, сайн хөрш байхыг эрмэлздэг. Манай үйл ажиллагаа болон хайгуулын хүчин чармайлт нь багийнхаа аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийг дэмжихэд чиглэгддэг.

2. Үнэнч шударга байдал

Бид нэр хүндээ хамгийн үнэ цэнтэй хөрөнгө гэж үздэг.

3. Шинжлэх ухааны үндэслэл

Бид хийж буй бүх зүйлээ шинжлэх ухааны үндэслэл дээр хэрэгжүүлдэг.

4. Санхүүгийн сахилга баттай удирдлага

Бид богино хугацааны ашиг орлогоос илүү урт хугацааны үнэ цэнийг бүтээхийг чухалчилж, өөриймсөг сэтгэлгээгээр ажилладаг.

5. Соёл ба гүйцэтгэл

Бид техникийн аюулгүй байдал, инновацийг үнэлдэг бөгөөд бүх түвшний ажлын байранд хамгийн шилдэг хүмүүсийг сонгож аван, тогтвортой ажиллуулахыг зорьдог. Бид үлгэр дуурайл үзүүлж, бие биенээ шударга, хариуцлагатай байхыг дэмжиж, өдөр бүр үнэт зүйлсээ тууштай хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

Бид бие биендээ үнэнч байж, хариуцлагатай хандах, өдөр бүр үнэт зүйлсээ тууштай хэрэгжүүлэхэд үлгэр дууриалал үзүүлж, бие биеэ дэмжиж ажилладаг.


Төслүүд

Занаду компанийн төслүүд нь Монголын порфирийн төрлийн зэсийн бүсэд байрладаг. Эдгээр нь Өмнөговийн палеозойн порфирын бүслүүрт (Гурвансайхан) оршдог бөгөөд энэ нь Девоны эриний сүүл үе, Карбониферийн палеозойн галт уулын болон тунамал чулуулгаас бүрдсэн 600х200 км хэмжээтэй нуман хэлбэртэй бүслүүр юм. Энэ нь Оюутолгойн зэс-алтны уурхай, Цагаан суваргын зэс-молибдены төсөл зэрэг байрласан Өмнөговийн бүс нутагт мэдэгдэж буй порфир болон интрузив эрдэсжилтийн нутаг юм. Энэхүү бүс нутагт Занаду хайгуул бизнес хөгжүүлэлтийн хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлж, төслийн шинэ боломжуудыг тасралтгүй эрэлхийлдэг.

Хармагтайн хамтын ажиллагаа

Хармагтай бол маш ирээдүйтэй зэс-алтны порфирын төсөл бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 420 км орчим зайд, Өмнөговь аймагт оршдог. Хармагтай төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийн ажил 2024 оны 3 дугаар улиралд дуусах төлөвтэй байна. Хармагтай төсөл нь ТЭЗҮ-ийн шатанд байгаа хэдий ч хайгуулын ажил эрчимтэй урагшилсаар байна.

Хармагтай төслийн ТЭЗҮ-ийн үе шатны бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхийн тулд 2023 оны 3-р сард Занаду компани “Зижин Майнинг Групп” ХХК (Зижин)-тэй стратегийн түншлэл байгуулсан. Занаду нь Хармагтай төслийн оператор бөгөөд ТЭЗҮ-г дуусах хүртэл материаллаг тогтвортой байдлын асуудлыг удирдан чиглүүлэх бөгөөд үүний дараа операторын үүрэг Зижин компанид шилжих нөхцөлтэйгөөр хамтран ажиллаж байна.



Улаан Уул

Улаан Уул зэс-алтны төсөл нь Монгол улсын өмнөд хэсэг Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт, Улаанбаатар хотоос зүүн урагш 420 км, Сайншандаас баруун тийш 70 км зайд оршдог. Геологийн нөхцөл нь олон төрлийн порфирын төрлийн зэс-алтны төвүүд, эрдэсжсэн турмалин брекч хоолой, зэс-алт/суурь металл магнетит скаргуудаас бүрддэг.

Улаан ууланд хийсэн өмнөх хайгуулын үр дүнд кварцын хүчтэй судалтай, үүнтэй холбоотой өндөр агуулгатай алтны эрдэсжилтийн өргөн бүсүүдийг тодорхойлсон.

Улаан Уул төсөлд 2023 онд өрөмдлөгийн ажил хийгдээгүй. Энэ хугацаанд Улаан уул төсөлд үйл ажиллагааны нэг ахлагч, хамгаалалтын албаны хоёр ажилтан ажилласан. Улаан уул төслийн хайгуулын ажил 2024 онд үргэлжлэн хийгдэж эхэлсэн.

Бусад төслүүд

Занаду нь Монгол улс болон хүрээлэн буй бүс нутагт зэс, алт зэрэг металлын салбарын төслүүдээ өргөжүүлэх нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлсээр байна. Бидний хөрөнгө оруулалтын шалгуурт нийцсэн төслүүдийг илрүүлэн Компанийн төсөлд оруулж, цаашид хөгжүүлэх арилжааны боломжуудийг эрэлхийлэн ажиллана.

Занадугийн гол төслүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб сайтад нийтэлсэн Техникийн тайлан болон бусад нийтлэлээс авах боломжтой.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

	Хэмжилт	2023	2022
Үйл ажиллагаа			
Нийт өрөмдлөг	Метр	71,932	0
Байгаль орчин			
1-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал	тонн CO ₂ e	1,627	179
2-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал	тонн CO ₂ e	8,657	5
Усны хэрэглээ	Метр ³	5,206	6,290
Хамт олон			
Үндсэн ажилчид	Тоо	56	29
Гэрээт ажилчид	Тоо	44	20
Хөдөлмөрийн чадвар алдахад хүргэсэн гэмтэл	Тоо	0	0
Хөдөлмөрийн чадвар алдах осол гэмтлийн давтамж	Тоо	0	0
Ажилчдыг сургах, ур чадварыг дээшлүүлэх	ажилласан хүн цаг	610	384
Сургалтанд хамрагдаж шалгалт өгсөн боловсон хүчин	Хувь	100	100
Олон нийт			
Орон нутгийн иргэдийн санал гомдол	Тоо	2	4
Орон нутгийн иргэдийн санал гомдлыг шийдвэрлэсэн	Тоо	2	4
Тэтгэлэг	Тоо	28	43
Засаглал			
Авлига, хээл хахуультай тэмцэх бодлогыг зөрчсөн тухай мэдээлэл	Тоо	0	0



Бид аюулгүй, хүртээмжтэй ажлын байранд хүмүүсийнхээ чадавхыг нэмэгдүүлэн ажиллахыг зорьдог

Бид орон нутгийн иргэдийг идэвхтэй дэмжиж тэдний хүсэл эрмэлзэл, эрхийг хүндэтгэдэг



Бид байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахын зэрэгцээ эрчим хүчний хэрэглээг бууруулах шилжилтийг дэмждэг.

Бид бизнесийн ёс зүйн хэм хэмжээг баримталж, ил тод байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээдэг



ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ХАНДЛАГА

Занаду нь хайгуулын компани ч гэсэн бид уул уурхайн олборлолтын мөчлөгийн бүхий л үе шатанд тогтвортой байдлын зарчмуудыг тусгасан байх ёстой гэж үздэг.

Занадугийн сүүлд шинэчлэгдсэн тогтвортой байдлын тогтолцоонд бид хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, орон нутгийн иргэд, ханган нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудад үнэ цэнийг бий болгоход анхаарах үндсэн дөрвөн чиглэлийг тодорхойлсон. Эдгээр чиглэлүүд нь компани өргөжин тэлэхийн хэрээр бид тогтвортой байдалд хэрхэн хандахыг тодорхойлдог.

Бид үйл ажиллагаагаа ил тод мэдээллэдэг.

2023 онд Занаду Тогтвортой байдлын бодлогоо шинэчилсэн бөгөөд тус бодлого нь тогтвортой байдлын зарчмуудыг бизнесийн үйл ажиллагаандаа тусгах үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Энэхүү шинэчилсэн бодлогыг өөрсдийн вэбсайт дээр олон нийтэд нээлттэй нийтэлсэн.

Бодит байдал

Тогтвортой байдлын талаар баримтлах хандлагыг мэдээлэх зорилгоор бид өмнө нь тогтвортой байдлын тогтолцооны чиглэл тус бүрийн хамгийн чухал сэдвүүдийг тодорхойлохын тулд бодит байдлын үнэлгээ хийсэн.

Сэдэв	Занаду Майнз-ийн хувьд ямар ач холбогдолтой вэ	Тайланд тусгагдсан
Уур амьсгалын өөрчлөлт	Бид эрчим хүчний хэрэглээг багасгах шилжилтэд чухал ач холбогдол бүхий ашигт малтмалын хайгуул болон олборлолт явуулж буй учир уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг аль болох багасгахыг хичээж ажиллах болно.	Байгаль орчин
Байгаль орчны менежмент	Бид байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийг хангах үүрэг хүлээж ажилладаг ба хайгуулын орчин үеийн, дэвшилтэт арга техникийг ашиглан одоогийн болон ирээдүйд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах болно.	Байгаль орчин
Газар болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн удирдлага	Бид өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй газар, орныг хүндэтгэн үзэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгахыг эрмэлздэг. Тогтвортой хайгуул, бүтээн байгуулалтын компанийн хувьд бид үйл ажиллагаа явуулж буй газар нутгийнхаа биологийн төрөл зүйл, экосистемийг хадгалахын төлөө ажиллана.	Байгаль орчин
Усны менежмент	Ус бол Монгол орны үнэт баялаг юм. Бид усны ашиглалт болон хэрэглээг сайтар хянаж, бохир ус зайлуулах үйл явцад хариуцлагатай ханддаг.	Байгаль орчин
Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	Бид бүх хүмүүст эрүүл, аюулгүй ажиллах орчинг бүрдүүлэхийг зорьдог	Хамт олон
Орон нутгийн иргэдийн хөгжил ба хөрөнгө оруулалт	Хөдөө орон нутагт нутгийн ард иргэдийг дэмжих, хөгжүүлэх тэдний богино хугацааны хэрэгцээг хангах, мөн урт хугацааны өсөлтийг хангах олон боломжууд байгаа. Иймээс бид жижиг бизнесүүдийг дэмжих, эрүүл мэнд, усны болон боловсролын чиглэлээр олон нийттэй хамтран орон нутгийн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.	Олон нийт
Орон нутгийн иргэдийн оролцоо	Манай компани бизнесийн үйл ажиллагаагаа нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх зорилгоор орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажилладаг, хариуцлагатай байгууллага юм. Бид орон нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэж, тэдэнтэй идэвхтэй хамтран ажилладаг.	Олон нийт
Ёс зүйтэй, ил тод байдлаар үйл ажиллагаа явуулах	Бид ил тод, ёс зүйтэй ажиллахыг зорилт болгодог. Энэ нь өөрийн ажилтан, гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, төрийн байгууллага болон үйл ажиллагаа явуулж буй орон нутагтай харилцахдаа шударга, ил тод байхыг хэлнэ.	Хариуцлагатай бизнес

Оролцогч талуудын оролцоо

Тогтвортой байдлын талаарх бидний хандлага нь хамгийн чухал оролцогч талуудыг тодорхойлж, бүлэг тус бүрт нөлөөлж буй эсвэл хамгийн анхаарал татаж буй сэдвүүд дээр анхааран ажилладаг.

Бид оролцогч талуудтайгаа үр дүнтэй харилцаж, харилцан ашигтай үр дүнд хүрэхийн тулд нээлттэй, шударга харилцаа, бусдын үзэл бодлыг хүндэтгэн ажиллахыг эрмэлздэг. Бид оролцогч талуудаа эрэмбэлэхдээ Занадугийн тэдэнд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ болон тэдгээрийн Занадуд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг авч үздэг.

Занаду нь байнгын оролцоог чухалчилсан стратегийг оролцогч талуудын бүлэг тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан. Бид эдгээр харилцааг хөгжүүлэх болон хадгалан авч үлдэхэд зориулагдсан боловсон хүчинтэй. Доорх хүснэгтэд эдгээр бүлгүүдтэй харилцах харилцааны мөн чанар болон бидний харилцааны давтамжийг хураангуйлан харуулав.

Оролцогч Бүлгүүд	Оролцогчийн Төрөл	Оролцооны Арга
Хувьцаа эзэмшигчид	Хувьцаа эзэмшигчид, шинжээчид	- Улирлын, жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан - Вэб хуудас, и-мэйл, хөрөнгө оруулагчдын мэдээлэл, нүүр тулсан/ биечилсэн уулзалтууд - Зах зээлийн мэдээлэл - Жил тутмын ерөнхий уулзалт - Салбарын хурал - Биечилсэн уулзалт
Үндсэн болон Гэрээт ажилчид	Удирдлага, үндсэн болон гэрээт ажилчид	- Ажилтнуудын мэдээлэл, - И-мэйл, олон нийтийн арга хэмжээ, мэдээллийн самбар, ажлын зааварчилгааны уулзалт, ажлын гүйцэтгэлийн уулзалт, - Нийтийн уулзалт - Шүгэл үлээх үйлчилгээ - Удирдлага ажилтнууд, багийн шууд харилцаа
Орон нутгийн иргэд	Орон нутгийн иргэд, олон нийт, газар эзэмшигчид	- Орон нутгийн харилцаа хариуцсан багийн томилолт - Орон нутгийн иргэдтэй хийх уулзалт - Сайт аялал - Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдлийг удирдлагад тогтмол танилцуулах - Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа
Ханган нийлүүлэгчид	Орон нутгийн болон орон нутгийн бус ханган нийлүүлэгчид	- Зах зээлд тулгуурласан арга барил - Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Гүйцэтгэлийн тогтмол уулзалт - Гэрээ хэлцэл
Засгийн Газар	Монгол улсын төрийн захиргааны болон, орон нутгийн төрийн байгууллага, Австралийн засгийн газар	- Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Жилийн эцсийн тайлан, вэб хуудас, - и-мэйл, гомдол санал, аудитын шалгалт - Зохицуулалтыг хангах, хэрэгжүүлэх - Орон нутгийн чухал асуудлуудад шууд харилцан хамтран ажиллах - Салбарын удирдлагын оролцоо

БАЙГАЛЬ ОРЧИН

Занаду нь дэлхийн хэмжээний чухал ач холбогдол бүхий ашигт малтмалын олборлолтын төслүүдийг тогтвортой байдлаар олж илрүүлэх мөн хөгжүүлэхийн төлөө ажилладаг. Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдэлийг бууруулах, орчин үеийн, дэвшилтэт хайгуулын арга хэрэгслүүдийг ашиглах стратегийн дагуу ажилладаг.

Занадугийн Төлөөлөн удирдах зөвлөл нь байгаль орчны асуудлуудад хяналт тавих чиг үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөл Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хороог ажиллуулж энэхүү үүргээ үр дүнтэй хэрэгжүүлдэг.

Энэхүү дэд хороо нь Занадугийн байгаль орчны санаачилга болон гүйцэтгэлийн асуудал хариуцсан удирдлагын дор ажилладаг бөгөөд байгаль орчны асуудлаар шийдвэр гаргуулах, сайжруулалт хийхтэй холбоотой асуудлаар ТҮЗ-тэй хамтран ажилладаг.

Байгаль орчинд чиглэсэн бидний арга барил, хандлагыг Тогтвортой байдлын бодлогоор зохицуулдаг бөгөөд та бүхэн тус бодлогыг манай вэбсайтаас харах боломжтой.

Уур амьсгалын өөрчлөлт

Занаду нь чухал ач холбогдолтой ашигт малтмалын төслүүдийн эрэл хайгуул, судалгааны явцад уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хүлээсэн үүргээ хэвээр хадгална. Ирээдүйд хэрэгжүүлэх хэд хэдэн металлын төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх нь Занадугийн өсөлтийн стратегийн чухал хүчин зүйл бөгөөд үүнд зэс, алт, никель багтана.

Бид уур амьсгалын өөрчлөлтийн бодлогоо боловсруулж, компанийн вэбсайт дээр олон нийтэд нээлттэй байршуулсан. Энэхүү бодлогод уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг бизнесийн шийдвэр гаргалтад авч үзэх, түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг олон нийтэд ил тод толилуулах үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

Нүүрстөрөгчийн ялгаралыг цэвэр дүнгээр тэг болгоход шилжих

Занаду нь чухал ач холбогдолтой ашигт малтмалын хайгуул болон олборлолтын салбарт идэвхтэй оролцогч хэвээр байна. Бид олон салбарыг цахилгаанжуулахад чухал хувь нэмэр оруулах, утаагүй дэлхийн үндсэн металл болох зэсийн нийлүүлэлтэд төвлөрч, хөрөнгө оруулалтаа хийх болно.

Салхи, нарны олон шинэ технологиуд нүүрсээр ажилладаг эрчим хүч үйлдвэрлэхээс хамаагүй бага нүүрстөрөгч ялгаруулдаг. Хэрэв бид утаагүй ертөнцөд амжилттай шилжихийг хүсвэл эдгээр технологийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна. Салхи, нарны технологид нэг МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд 8000 кг хүртэл зэс шаардлагатай байдаг бол ердийн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд ердөө 1000 кг зэс шаардлагатай байдаг. Дэлхий дахинд эрчим хүч үйлдвэрлэх шинэ хэлбэрийг нэвтрүүлэхийн хэрээр Занадугийн зэсийн нөөцийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна.

Хармагтайн хамтын ажиллагаа

Занадугийн 2023 оны үйл ажиллагаа урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулахад шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Эдгээр төслүүдийг 2024 онд дуусгахаар төлөвлөж байгаа бөгөөд үүний дараа ашигт малтмалын олборлолт явуулах шийдвэр гарна.

Занаду нь хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад чиглэсэн уул уурхайн технологи, үйл явц бүхий эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Үүнтэй холбоотой урьдчилсан ТЭЗҮ-д дараах саналуудыг авч үзэж байна. Үүнд:

- Эрчим хүчний хэрэглээний -50%-ийг нарны болон салхины эх үүсвэрээс, -50%-ийг төвийн эрчим хүчний сүлжээнээс тэнцүү хэмжээгээр авах судалгаа.
- Хайбрид-цахилгаан тээврийн хэрэгсэл, цахилгааны агаарын шугам, уурхайн бутлах болон дамжуулах системийн хувилбаруудын судалгаа.
- Эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх, усны зарцуулалтыг бууруулах зорилгоор овоолгыг өтгөрүүлэх болон далангийн дизайн.
- Олборлосон нэг тонн зэсэнд зарцуулагдах цахилгаан эрчим хүчний хэмжээ (ГДЖ)-г бууруулах зорилготой хүдрийн флотацийн баяжуулалт.
- Эрчим хүчний хэмнэлттэй туслах дэд бүтэц.

1 болон 2-р зэрэглэлийн хүлэмжийн хийн ялгаруулалт

Уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг багасгах амлалтын хүрээнд бид хүлэмжийн хийн ялгарлын эрчмийг бууруулах олон төрлийн үнэлгээ хийдэг.

2023 онд Хармагтай төслийг цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбосон. Энэ нь дизель түлшнээс хамаарсан эрчим хүчний хэрэглээг бууруулж, компанийн одоогийн үйл ажиллагаа болон цаашдын бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан эрчим хүчний илүү цэвэр, найдвартай эх үүсвэрийг ашиглах боломжийг бий болгосон юм.

Цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдоход дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болсон. Үүнд: шаардлагатай зөвшөөрөл авах, дэд бүтцийг суурилуулах ажилд гэрээт гүйцэтгэгчийг ажиллуулах, Монгол улсаас гадна байрлах цахилгаан эрчим хүч нийлүүлэгчтэй холбоотой геополитикийн эрсдэлийг зохицуулах гэх мэт. Энэ санаачилга нь цаашид Хармагтай төслийн нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг бууруулна гэдэгт бид итгэлтэй байна.

2023 онд компанийн үйл ажиллагааны улмаас 10,283.82 тонн нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂e) ялгарсан байна. Үүнээс, 1-р зэрэглэлийн хувьд 1,626,64 тонн CO₂e, харин 2-р зэрэглэлийн хувьд 8,657,18 тонн CO₂e ялгаруулсан байна. 2023 онд 1 ба 2-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтын эрчим өрөмдсөн метр тутам 0.14 тонн CO₂e байна.

Өрөмдлөгийн үйл ажиллагаа 2023 онд эрчимтэй нэмэгдсэнтэй холбоотой 1 ба 2-р зэрэглэлийн нийт ялгаруулалт 183.89-аас 10,283.82 тонн CO₂e болж өссөн байна.

Ялгарал	2023	2022
1-р зэрэглэл	1,627	179
2-р зэрэглэл	8,657	5
1 болон 2-р зэрэглэл	10,284	184

Байгаль орчны Менежмент

Занаду нь байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийг ханган ажилладаг.

Байгаль орчны хууль, тогтоомжийн нийцлийг хангахтай холбоотой үүрэг хариуцлагыг Тогтвортой байдлын шинэчилсэн бодлогод тусгасан болно.

Занаду нь байгаль орчны хууль, тогтоомжийн шаардлагын нийцлийг хангах, дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэг амлалтын хүрээнд жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулан, орон нутгийн засаг захиргаанд хүргүүлдэг. 2023 онд БОМТ-г Өмнөговь болон Дорноговь аймгуудад хүргүүлж, батлуулсан. Түүнчлэн орон нутгийн байгаль орчны байгууллагуудаас явуулдаг байгаль орчны хууль, тогтоомжийн нийцлийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагддаг юм.

2023 онд өрөмдлөгийн үйл ажиллагаа нэмэгдсэн учир бидэнд хууль, тогтоомжийн нийцлийн үүрэг хариуцлага мөн нэмэгдсэн. Түүнчлэн Монгол улсын хэмжээнд хэрэгжүүлж буй уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл явцад орон нутгийн иргэд болон засаг захиргааны байгууллагууд ихээхэн анхаарал хандуулах болсон. Эдгээр хүчин зүйлүүд болон байгаль орчны эрх зүйн орчин цаашид улам хүндрэх магадлалтай гэж бид таамаглаж байгаа тул 2023 онд нийцлийн үйл ажиллагааг удирдах, байгаль орчны үнэлгээ хийх зорилгоор Байгаль орчны зохицуулагчтай болсон.

Хармагтай төслийн талбайд 2023 онд Цогтцэций сумын Нөхөн сэргээлтийн хяналт шалгалт, Манлай сумын Усны хайгуулын хяналт шалгалт болон Өмнөговь аймгийн Байгаль орчны хяналт шалгалт зэрэг гурван удаагийн хяналт шалгалт хийгдсэн.

Занаду компани нь хяналт шалгалтад амжилттай хамрагдаж, аливаа зөрчилгүй, байгаль орчны холбогдох бүхий л дүрэм журмыг дагаж мөрдөж байгааг дуулгахад таатай байна.

Занадугийн урьдчилсан ТЭЗҮ-ийн хүрээнд 2023 онд бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ) болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бие даасан үнэлгээ (БОННҮ)-г эхлүүлсэн. Эдгээр үнэлгээг 2024 онд дуусгах бөгөөд үүнд байгаль орчны хууль тогтоомжийн шаардлагатай харьцуулсан зөрүүгийн дүн шинжилгээ багтаж байгаа юм. Ингэснээр Хармагтай төслийн олборлолт эхлэхэд хууль тогтоомжийн шаардлагыг үргэлжлүүлэн хангах нөхцөл бүрдэх юм.

Занаду нь байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001 стандартын гэрчилгээ аваагүй байгаа хэдий ч бид цаашид хайгуулын үйл ажиллагаагаа өргөжүүлэхдээ үүнийг анхааран авч үзнэ.

Газар болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн удирдлага

Бид өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй газар, орныг хүндэтгэн үзэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгахыг эрмэлздэг. Тогтвортой хайгуул, бүтээн байгуулалтын компанийн хувьд бид үйл ажиллагаа явуулж буй газар нутгийнхаа биологийн төрөл зүйл, экосистемийг хадгалахын төлөө ажиллана.

2023 онд хийгдсэн хайгуулын үйл ажиллагаа зөвхөн Хармагтай төслийг хамарсан бөгөөд хайгуул хийгдсэн тухайн бүсэд тусгай хамгаалалттай газар байхгүй.

Шинэчлэн боловсруулсан Тогтвортой байдлын бодлогод биологийн төрөл зүйлийг хамгаалах, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үүрэг хариуцлагыг

тодорхойлсон болно. Өрөмдлөгийн явцад харьцангуй бага хэмжээний талбай (ихэвчлэн 20м х 20м) эвдрэлд ордог бөгөөд өрөмдлөг хийж дууссаны дараа бүх талбайг байгалийн өвс, ургамлын үрээр нөхөн сэргээдэг. Хөрсний эвдрэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Сонгосон өрмийн талбайд ургамал бүхий өнгөн хөрсийг ялгаж, өрөмдлөг дууссаны дараа буцааж дэвсдэг.
- Зөвхөн шаардлагатай тохиолдолд шуудуу ухаж, өнгөн хөрсийг тусад нь хадгалдаг.
- Газрын налуу хэсгийг хөрсний элэгдлээс хамгаалах зорилгоор суваг хийж өгдөг.

Занаду компанийн урьдчилсан ТЭЗҮ-ийн хүрээнд 2023 онд Хармагтай төслийн биологийн олон янз байдлын өргөн хүрээг хамарсан БОНБНҮ-г эхлүүлсэн. Энэхүү үнэлгээг 2024 онд хийж дуусгах бөгөөд тус үнэлгээгээр биологийн олон янз байдлын тодорхойгүй байгаа эрсдэлийг тодорхойлох юм. Хармагтай төслийн олборлолт эхлэхээс өмнө дараагийн нөлөөллийг бууруулах төлөвлөгөө шаардлагатай байж болно.

2024 онд Улаан Уул төслийн хайгуулын ажил үргэлжилнэ. Энэхүү төслийн хувьд газар болон биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг удирдахдаа Хармагтай төсөл дээр хэрэгжүүлсэн зарчмуудыг ашиглана.



Усны менежмент

Ус бол Монгол орны үнэт баялаг гэдгийг бид хүлээн зөвшөөрдөг. Бид усны ашиглалт болон хэрэглээгээ сайтар зохицуулж, бохир ус зайлуулах үйл явцад хариуцлагатай ханддаг.

Хэрэглэж буй бух усаа Хармагтай төслийн талбайн гүний уст давхаргаас авдаг. Усны менежментийн стратегийн хүрээнд бид орон нутгийн иргэдийн ашиглаж буй худгаас өөр үйлдвэрлэлийн зориулалттай худаг гаргаж, хайгуулын үйл ажиллагаанд шаардлагатай усаа хангаж байна.

2023 онд бид 5206 м3 ус ашигласан.

	2023	2022	2021	2020
Ашигласан ус (м³)	5,206	6,290	N/A*	11,548

2021 онд мэдээлэл тавигдаагүй

Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах болон нөхөн сэргээх тухай хууль тогтоомжийн шаардлагыг Занаду мөрдлөг болгон ажилладаг. 2023 онд Өмнөговь аймгийн Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Хармагтай төсөлд хяналт шалгалт хийсэн бөгөөд үүгээр усны бохирдолтой холбоотой зөрчил илрээгүйг дурьдахад таатай байна.

Усны менежментийг тасралтгүй сайжруулах ажлын хүрээнд бид 2023 онд бохир усны септик системийг суурилуулсан. Энэхүү систем нь ашигласан усыг цэвэршүүлж, ойр орчмын уст үеийг бохирдуулахгүйгээр хөрсөнд аюулгүй шингээх боломжийг олгодог. 2024 онд Хармагтай төслийн бүх ашигласан усыг энэхүү системээр цэвэрлэнэ.

Урьдчилсан ТЭЗҮ-ийн хүрээнд 2024 онд усны хайгуулын ажил дуусна. Эдгээр үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн ашиглаж буй худагт нөлөөлөхгүйгээр уул уурхайн үйл ажиллагаанд хангалттай устай байх боломжийг олгоно.



БОДИТ ЖИШЭЭ

Бохир ус цэвэрлэх - Септик систем

Компани ажилтнуудынхаа ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор хоёр дахь удаагаа ажилчдын байр, сууцыг Хармагтай анги дээр барьж ашиглалтад оруулсан. Энэхүү төслийн хүрээнд бид бохир устай холбоотой шийдэлд нэгэн чухал алхмыг хийсэн.


Бохир усыг цэвэршүүлэх асуудал нь ашигт малтмалын хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд тавигдах байгаль орчны чухал шаардлага бөгөөд орон нутгийн засаг захиргаа болон нийгэмд чухал ач холбогдолтой юм. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор цэвэршүүлсэн усыг хөрсөнд уусгах орчин үеийн бохир ус цэвэршүүлэх системд хөрөнгө оруулалт хийсэн.

Засгийн газраас Хармагтай төслийг Өмнөговь аймагт бохир ус цэвэршүүлэх оновчтой шийдлийг суурилуулсан анхны хайгуулын төсөл хэмээн цоллосон.


ХАМТ ОЛОН

Занаду компанийн хайгуулын төслүүд нь төсөл хэрэгжиж буй орон нутгийн эсвэл зэрэгцээ сумдын иргэдэд өндөр чанартай ажлын байрыг бий болгодог. Эдгээр боломжийг олгохдоо үндсэн болон гэрээт ажилтнууддаа эрүүл, аюулгүй ажлын байрыг хангах үүрэг хүлээдэг.

Монголд ажиллаж буй Үндсэн болон Гэрээт ажилчдын нийт тоо



Эмэгтэй ажилчдын хувь
Үндсэн болон Гэрээт ажилчдыг хамруулсан





Хөдөлмөрийн аюулгүй байдал ба Эрүүл мэнд

ТУЗ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сөрөг үр дагаварт хүргэх аливаа эрсдлийг бууруулах үүрэгтэй. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд болон байгаль орчны хороо нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дотоод тайлангийн тогтолцооны тохиромжтой байдлын талаар удирдлагуудаас ирүүлсэн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах үүрэгтэй ба холбогдох бүхий л хууль тогтоомжийн шаардлагын хэрэгжилтийг хариуцдаг.

Занаду нь хайгуулын үйл ажиллагаа явуулдаг компани учир үүнтэй холбоотой манай ажилтнууд хэд хэдэн эрсдэлд өртөх магадлалтай. Тээврийн хэрэгсэл жолоодох, ашигт малтмал, усны хайгуул хийх, дээж боловсруулах шинэ байгууламж барих зэрэг нь 2023 оны аюулгүй байдлын хамгийн том эрсдэл гэж тодорхойлсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс аюулгүй байдлын аюул, ослын талаар тогтмол мэдээлэл авч ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг. Манай компани нь ослын бүртгэл ба осол тохиолдох дөхсөн тохиолдлын бүртгэлийг хөтөлдөг бөгөөд үүнийг өдөр бүр мэдээлж, долоо хоног бүрийн урьдчилсан ТЭЗҮ-ийн хурлаар хэлэлцдэг.

Манай Тогтвортой байдлын бодлого нь аюулгүй, эрүүл ажлын байраар хангах Занадугийн үүрэг хариуцлагыг илэрхийлдэг. Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдлийг бууруулахын тулд бүхий л үйл ажиллагааны заавар журмыг Монгол хэл дээр боловсруулсан. Энэ нь манай орон нутгийн ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид ослын хариу арга хэмжээ, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ойлгож, хэрэгжүүлэх боломжтой гэсэн үг юм. Аюулгүй ажиллагааны журмыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны зохицуулагч шинэчилж, шаардлагатай тохиолдолд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар батлуулна. Тухайн жилд Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, Аяллын менежментийн төлөвлөгөө болон Кемпийн менежментийн төлөвлөгөөг шинэчилсэн. Мөн бид үндсэн үйл ажиллагааны бодлогыг шинээр боловсруулсан.

Ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид ажил үүргээ аюулгүй гүйцэтгэхэд бэлэн байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор ээлж эхлэхийн өмнө согтууруулах ундааны тест хийдэг. 2023 онд нийт 2112 удаагийн согтууруулах ундааг амьсгалаар илрүүлэх тестийг хийсэн байна.

Тайлангийн хугацаанд ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчдийг ажил эхлэхийн өмнөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаанд өдөр бүр хамруулсан. ХАБЭА-н зохицуулагч сар тутам хөдөлмөрийн аюулгүй байдлын тодорхой нэг сэдвийг сонгон, мэдээлэл өгч ажилладаг. Ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид тохиолдолж болох аюул, осол эрсдлийн талаар ээлжийн ахлагчдаа мэдээллэх үүрэгтэй. Мөн өрмийн талбай кэмпэд зочилж буй зочдод аюулгүй байдлын зааварчилгаа өгч байна.

2023 онд Занаду нь эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын бүхий л холбогдох дүрэм журмыг мөрдөж, үүний үр дүнд аливаа зөрчилгүй ажилласан. 2023 онд өрөмдлөгийн хэмжээ нэмэгдсэн, урьдчилсан ТЭЗҮ-д шаардлагатай арга хэмжээнд илүү олон гэрээт гүйцэтгэгчид сайт дээр байсан, үүнтэй холбоотой нийт 328,883 хүн/цаг ажилласан хэдий ч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдол бүртгэгдээгүй ба энэ үзүүлэлтэд эрүүл мэнд өвчлөлийг багтаасан болно.

2023 онд Занаду компани нь эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт санхүүжилт олгосон ба ингэснээр ажилтнууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үргэлжлүүлэн авах боломжтой болсон. Гурван сарын туршилтын хугацаа дууссан, Занаду компанийн үндсэн ажилтнууд уг хөтөлбөрт хамрагдах боломжтой юм. Мөн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу нийт ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчдийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж байна.



БОДИТ ЖИШЭЭ

Дээж боловсруулах байгууламж

Хармагтай хээрийн ангийн хайгуулын дээж боловсруулах байгууламжийг 2000-аад оны эхээр барьсан бөгөөд энэхүү хуучин байгууламж нь манай ажилтнууд болон төсөлд хэд хэдэн ХАБЭА-н аюул учруулж байсан учир 2023 онд ашиглалтаас гаргасан.

Урьдчилсан ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалтаар дээж боловсруулах ажиллагаа, оффис, агуулах болон машин техник тоног төхөөрөмжийн шинэ, орчин үеийн 2000 мкв талбай бүхий байгууламжийг барьж, 2023 оны 11-р сард ашиглалтад оруулсан.

Тус хөрөнгө оруулалт нь ажилтнуудаа эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны олон улсын стандартад нийцсэн чанартай ажиллах нөхцөлөөр хангах тухай компанийн үүрэг хариуцлагыг харуулж байна. Шинэ байгууламж ашиглалтад орсны дараа хуучин байгууламжийг буулгаж, ХАБЭА-н аюулыг арилгасан юм.

ОРОН НУТАГ

Бид Монгол улсад тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хайгуулын шилдэг компани байхыг эрмэлздэг. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд бид орон нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэж, тэдний хүсэл эрмэлзлэлийг дэмжих арга замыг идэвхитэй эрэлхийлж байна.

Занаду нь орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг дараах 5 чиглэлд тодорхойлсон. Үүнд:



Орон нутгийн тогтвортой амжиргааг дэмжих



Нийгмийн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх



Байгаль орчныг хамгаалах



Соёлын өвийг хамгаалах



Боловсролыг дэмжих



Хамтын ажиллагаа

Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад хамтын үнэ цэнийг бий болгох зорилгоор бид орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажилладаг. Ингэснээр манай хайгуулын үйл ажиллагаа нь төслийн талбай дээрх эсвэл зэргэлдээ орших нутгийн иргэдийн ашиг сонирхолд нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Уул уурхайн үйл ажиллагаа нь ихэвчлэн нутгийн уугуул иргэдийн нутаг дэвсгэр эсвэл ойролцоох нутаг дэвсгэр дээр явагддаг бөгөөд бид тэдний эрхийг хүндэтгэж, санаа бодлыг нь байнга сонсож, хамтраж ажилладаг.

Бид хайгуулын үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа хүндтэй зочид байхыг эрмэлзэхийн зэрэгцээ санал, гомдол хэдийд ч гарч болзошгүй тул нээлттэй, хариуцлагатай байх соёлыг төлөвшүүлэхийг зорьж байна. Мөн 2023 онд өргөтгөсөн өрөмдлөгийн хөтөлбөртэй холбоотой орон нутгийн иргэдээс санал, гомдол гарч болзошгүйг бид таамаглаж байсан.

Манай хамтын ажиллагааны стратегийн хүрээнд бид орон нутгийн харилцааны зохицуулагчийг үндсэн ажилтнаар ажиллуулдаг бөгөөд түүний ажил үүргийн нэг чухал хэсэг нь Занаду болон төсөл хэрэгжиж буй орон нутгийн иргэд хоорондын хамтын ажиллагааг хангах, иргэдийн санал хүсэлт болон гомдлыг цаг алдалгүй, үнэнч шударгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллахад оршино. Энэхүү зохицуулагч нь орон нутгийн ард иргэдийн соёлыг сайн мэддэг, ойлгодог

Монгол улсын иргэн юм.

Хэрэв орон нутгийн иргэн манай компанийн үйл ажиллагааны талаар гомдол гаргах, саналаа илэрхийлэх бол олон нийттэй харилцааны зохицуулагчтай биеэр уулзаж, ярилцана. Уулзалтын дараа гомдол, санал хүсэлтээ Үйл ажиллагаа хариуцсан захиралд бичгээр гаргах боломжтой.

Хамтын ажиллагааны стратегийг цаашид дэмжих зорилгоор бид орон нутгийн иргэдэд зориулсан шууд холбоо барих утсыг ажиллуулсан.

2023 онд ус болон тоосны менежменттэй холбоотой хоёр гомдол ирсэн. Эдгээр хоёр гомдлыг шийдвэрлэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.

2024 онд бид урьдчилсан ТЭЗҮ-д зориулан хамтын ажиллагааны шинэ төлөвлөгөө болон стратегийг боловсруулна.

	2023	2022	2021	2020
Орон нутгийн иргэдээс ирүүлсэн гомдол (тоо)	2	4	0	0
Орон нутгийн иргэдээс ирүүлсэн гомдол шийдвэрлэсэн байдал (тоо)	2	4	0	0

Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт

Хөдөө орон нутагт нутгийн ард иргэдийг дэмжих, хөгжүүлэх олон боломж байгааг бид ойлгож богино хугацааны хэрэгцээг хангах замаар урт хугацааны өсөлтөд хүрэх боломжийг олгоход анхаарч байна.

Тиймээс бид жижиг бизнесийг хөгжүүлэх, эрүүл мэнд, ус, боловсрол гэсэн дөрвөн чиглэлээр орон нутгийн санаачлагыг дэмжих зорилгоор нутгийн иргэдтэй хамтран ажилладаг.

Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалтын стратегийг дэмжих зорилгоор бид орон нутгийн холбогдох засаг захиргааны байгууллагуудтай жил бүр Нийгмийн хамтын ажиллагааны гэрээг байгуулан хамтран ажиллаж байна.

Энэхүү гэрээнд бидний сонгосон хамтын ажиллагааны хөтөлбөрүүд болон эдгээр хөтөлбөрүүдийг дэмжих санхүүгийн үүрэг хариуцлагуудыг тодорхойлсон байдаг.

Занадугийн зүгээс Цогтцэций сум болон Билгэх баг (хоёул Хармагтай төсөл)-тай байгуулсан 2023 онд гэрээнд заасан хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж дууссаныг дуулгахад таатай байна.


2024 онд Занадугийн хувьд Манлай сум (Хармагтай төсөл), Цогтцэций сум болон Билгэх багтай гэрээ байгуулан хамтран ажиллана.

Боловсрол

Занаду компани 2015 оноос орон нутгийн иргэд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод дээд боловсрол эзэмшихэд зориулан тэтгэлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

2023 онд бид энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлж Хармагтай болон Улаан Уулын төслийн орчмын орон нутгийн иргэдэд зориулсан 28 тэтгэлэг баталсан. Бид төрөл бүрийн мэргэжлээр их дээд сургуульд элсэхэд нь зориулан энэхүү тэтгэлэгийг олгодог. Энэхүү тэтгэлэгт 25 оюутан залуус 15 их, дээд сургуульд 13 төрлийн мэргэжлээр суралцахаар сонгогдсон байна.

Хармагтай төсөл орчмын сургуулийн өмнөх насны хүүхдүүд хамрагдах цэцэрлэгийн анги танхимыг шинэчлэх зорилгоор 2021 онд STAR хөтөлбөрийг эхлүүлж, 2023 онд хоёр анги танхимыг тохижуулж, засвар үйлчилгээ хийсэн. Бид энэхүү хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд 2024 онд дахин хоёр анги танхимыг тохижуулж, засвар үйлчилгээ хийхээр төлөвлөөд байна.



Тайлбар: 2022 оны тэтгэлэгийн тоонд өмнөх мэдээлсэн өгөгдөл мэдээлэл багтсан болно.

Жижиг бизнесийг хөгжүүлэх

Занаду нь хайгуул явагдаж буй нутаг дэвсгэр эсвэл ойролцоо амьдардаг иргэдийн эдийн засгийн хөгжлийг идэвхтэй дэмждэг. Боломжтой тохиолдолд бид урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж дуусгахын тулд дотоодоос бараа, үйлчилгээ худалдан авдаг. 2023 онд Хармагтай төсөлд шинэ жимс, хүнсний ногоо нийлүүлэх дөрвөн улирлын хүлэмжийн төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү хүлэмжийг барихад орон нутагт үйлдвэрлэсэн материал, үйлчилгээг ашигласан болно.

Үс

Бидний хайгуул хийж буй орон нутгийн иргэд ахуйн хэрэгцээгээ хангах, мал сүргээ маллахдаа цэвэр уснаас хамааралтай амьдардаг. Занаду өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч нартай хамтран төслийн талбайд 2-3 жил тутамд 100 м гүнтэй гүний усны худгуудгийг өрөмдөж сайн чанарын усаар хайгуулын талбай орчмын нутгийн ард иргэдийг хангах үүрэг хүлээсэн.

2023 онд Занаду компани Хармагтай төслийн талбайд шинэ усны цооног өрөмдөж, тоноглож, ард иргэдэд онцгойлон ашиглуулахаар болсон.

Занаду усны чанарыг тодорхойлохын тулд гидрологийн судалгаа болон хэмжилтийг үргэлжлүүлэн хийж, усны генератор, насос төхөөрөмжөөр хангаж, тэдгээрийн хэвийн ажиллагааг хангах үүднээс тухайн худгуудын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Бид 2023 онд ойролцоогоор Хармагтай төслийн бүс нутаг дахь 4 худагт сар тутам 20 удаагийн хэмжилтийг хийсэн байна.

Эрүүл мэнд

Занаду компани Цогтцэций сумын эмнэлэгтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, он гарсаар эмнэлгийн болон хөргөлтийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Тус эмнэлэг нь Хармагтай төслөөс 100 км зайд байрладаг бөгөөд 7300 гаруй иргэнд үйлчилдэг. Цогтцэций сумын эмнэлэгтэй хамтран ажилласнаар тус бүс нутгийн иргэдэд болон Занаду компанийн ажилчид болон шаардлагатай тохиолдолд гэрээт гүйцэтгэгч нарт чанартай эмнэлгийн тусламж үзүүлэх боломжтой болох юм.

Бусад санал санаачлагууд

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Овоо тахилга” ёслолыг Хармагтай бүс нутгийн соёлын хамгийн чухал арга хэмжээ хэмээн олон нийт үнэлдэг. Занаду жил бүр энэхүү арга хэмжээг дэмжсээр ирсэн.

Цогтцэций сумын 100 жилийн ой 2024 онд тохиох бөгөөд ойн баярыг тохиолдуулан Занаду компани санхүүгийн дэмжлэг үзүүлж, соёлын төвийн барилгын тохижилтын ажлыг гүйцэтгэж, хяналтын камер суурилуулахаар төлөвлөж байна.



БОДИТ ЖИШЭЭ

Орон нутгийн цэцэрлэг

Бид “Билгэх баг” цэцэрлэгийн тохижилт болон засварын ажлыг гурав дахь жилдээ үргэлжлүүлэн хийж байна.

Тус цэцэрлэгт Хармагтай орчмын 320 хүүхэд хамрагддаг. Хармагтай багийн хувьд цэцэрлэгийн хөгжлийн төсөл бол манай компанийн хамгийн үнэ цэнэтэй төслүүдийн нэг юм. Билгэх баг төдийгүй улсын хэмжээнд хамтын ажиллагааны жишиг гэж бид үздэг.


2023 онд манай компани цэцэрлэгийн 2 ангийг тохижуулж, засвар үйлчилгээ хийсэн бол 2024 онд 4 ангийг нэмж тохижуулж, засвар хийхийг зорьж байна. Энэхүү төслийн үр дүнд ангиудыг гал тогоо, ширээ, сандал бүхий хооллох хэсэг, эко тоглоом бүхий тоглоомын хэсэг, хүүхэд тус бүрт ор, ариун цэврийн өрөөний суултуур болон тосгуур зэргээр хангах юм.



ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕС

Бид өөрсдийн бизнесийг ил тод, ёс зүйтэй хийж гүйцэтгэхийг эрмэлздэг. Энэ нь бид өөрсдийн ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид, төрийн байгууллага болон үйл ажиллагаа явуулж буй орон нутагтай харилцахдаа шударга байна гэсэн үг юм.





Бизнесийн ёс зүй ба ил тод байдал

Занадугийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ур чадвартай, туршлагатай гишүүдээс бүрддэг бөгөөд үнэ цэнийг хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад ёс зүйтэй, ил тод байдлаар бий болгодог. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо тогтмол хянаж ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрэмд зааснаар захирлуудын дийлэнх нь гүйцэтгэх бус гишүүд байх шаардлагатай бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл таван захирлаас бүрдсэн, тэдгээрийн гурав нь гүйцэтгэх бус захирлууд юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, ур чадвар, туршлагыг 2023 оны жилийн тайланд тусгасан бөгөөд мөн компанийн вэб сайтад байршуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрмийн нэг шаардлага бол ТУЗ-ийн дарга нь хараат бус, гүйцэтгэх бус захирал байна. 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлын албыг давхар хашдаг болсон тул тус шаардлага биелээгүй.

Занаду 2023 оны эхээр менежементийн өөрчлөлт болон шаардлагатай ур чадвар нь Компани болон төслүүдийн хөгжлийн үе шатад чухал хэрэгцээтэй гэж үзсэн. Занадугийн хөгжлийн өнөөгийн үе шатанд тохирсон Төлөөлөн удирдах зөвлөлийн орон тоог хэвээр хадгалахын тулд одоогийн ерөнхийлөгч ноён Колин Мурхедийн туршлагыг бүрэн ашиглах, захиргааны зардлыг багасгах зорилгоор Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн даргын албан тушаалыг нэгтгэх нь зүйтэй гэж үзсэн.

Одоогийн байдлаар Компанийн стратегийг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх ТУЗ-ийн дараах дөрвөн хороо байдаг. Үүнд: Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хороо; Аудит, эрсдэлийн хороо болон Хараат бус хороо. Хороодын дүрмийг компанийн вэб сайтад байршуулсан болно.

Дүрэмд Нэр дэвшүүлэх, урамшууллын хороо болон Аудит, эрсдэлийн хорооны бүх гишүүд бие даасан, гүйцэтгэх бус захирлууд байхыг шаарддаг. Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны хорооны бүх гишүүд бие даасан, гүйцэтгэх захирал байх албагүй гэхдээ энэ нь хорооны даргад шаардлагатай. 2023 онд Занаду компанийн дарга нь Гүйцэтгэх захирлын албыг давхар хашиж байсан тул эдгээр амлалтаа биелүүлээгүй. Өмнөх хуудсанд дурдсанчлан энэ нь сонирхогч талууддаа ашигтай бөгөөд шаардлагатай гэж Компани үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хороо 2023 оны 4, 7 болон 12 дугаар саруудад хуралдсан. Хороо жилд хамгийн багадаа хоёр удаа хуралдах ёстой ч Хорооны дарга шаардлагатай гэж үзвэл түүнээс олон удаа хуралдах боломжтой.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хорооны 2023 онд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

- Аюулгүй байдлын гүйцэтгэл
- Эрүүл мэндийн үзүүлэлтүүд
- Байгаль орчны үзүүлэлтүүд
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны удирдлагын систем
- Олон нийтийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- 2023 оны Тогтвортой байдлын тайланг бэлтгэх.

Хармагтай төслийн урьдчилсан ТЭЗҮ-г богино хугацаатай гэрээт гүйцэтгэгчид дэмжиж байсан тул ёс зүйгүй зан чанарын эрсдэлийг менежмент 2023 онд хамгийн чухал асуудал байсан бөгөөд бид нийт ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчдэдээ гарын авлагаа монгол хэл дээр бэлтгэн гаргасан.

Ёс зүйн дүрэм

Манай ёс зүйн дүрэмд захирал, ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, зөвлөх болон ханган нийлүүлэгчдийн зан чанарын стандартыг тодорхойлдог. Дүрэмд дараах шаардлагуудыг тусгасан:

- Ёс зүйтэй бизнес эрхлэх (хээл хахууль, авлигын эсрэг)
- Хөдөлмөр эрхлэлтийн практик (тэгш боломжоор хангах, ялгаварлан гадуурхах, дарамтлах, түрэмгийлэхийг үл тэвчих)
- Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөрийн аюулгүй байдал
- Олон нийт ба байгаль орчин.

ТУЗ-ийн бүх захирлууд болон Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал зэрэг бүх Гүйцэтгэх удирдлагууд энэхүү дүрмийг дагаж мөрддөг.

Авилга, хээл хахуулийг үл тэвчих

Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого (АААЭБ) нь бидний бизнесийн харилцаа болон үйл ажиллагаанд аливаа авлига, хээл хахуулийг үл тэвчих тухай тусгасан. Бодлогын бүх ажилтнууд дагаж мөрддөг. Авлига, хээл хахуулийн эсрэг бодлогыг компанийн вэбсайтаас харах боломжтой.

Манай компани 2023 оны туршид тус бодлоготой нийцүүлэн улс төрийн аливаа хандив өгөөгүй.

Бодлогын дагуу бүх ажилтнууд гуравдагч этгээдээс хүлээн авсан эсвэл төлбөрийг төлсөн бэлэгтэй холбоотой зардлын тайлан гаргаж, зардлын шалтгааныг бүртгэдэг. Бодлогыг зөрчсөн бүхий л тохиолдлыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Аудит, эрсдэлийн хороонд тайлагнана. 2023 онд Бодлогыг зөрчсөн тохиолдол гараагүй болно.



Цаг тухайд нь мөн Тасралтгүй Тайлагнах

Тасралтгүй байх зарчим ба хувьцаа эзэмшигчдийн харилцааны бодлого (ТБХЭХБ) нь хувьцаа эзэмшигчид болон зах зээлд үйл ажиллагааныхаа талаар бүрэн, цаг алдалгүй мэдээллээр хангах тухай тусгасан. Бодлогыг компанийн вэбсайтаас харах боломжтой.

2023 онд Занаду Австралийн үнэт цаасны бирж болон Торонтогийн хөрөнгийн биржээр дамжуулан 69 мэдэгдэл хийсэн бөгөөд тасралтгүй ил тод байх дүрмийг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй болно.

Орчин цагийн боолчлол

Занаду орчин цагийн боолчлол, хөдөлмөрийн мөлжлөгийн асуудалд нухацтай ханддаг. Нийлүүлэлтийн сүлжээнд хөдөлмөрийн мөлжлөгтэй тэмцэх үүрэг хариуцлагыг Занадугийн Хүний эрхийн (ХН) бодлогод тусгасан. Хүний эрхийн бодлогын хуулбарыг компанийн вэбсайтаас харах боломжтой.

Бид өрөмдлөг, геофизикийн судалгаа, үндсэн шинжилгээний үйлчилгээгээ Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн урт хугацааны харилцаатай Монгол улсын ханган нийлүүлэгч байгууллагуудаас авч орчин үеийн боолчлолын эрсдэлийг бууруулах идэвхитэй арга барилыг баримталж ирсэн. Монгол улсын Үндсэн хуульд аливаа хэлбэрээр албадан хөдөлмөр эрхлэхийг хориглосон байдаг бөгөөд Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд хүүхдийн хөдөлмөр эрхлэхийн аливаа хэлбэрийг хориглосон байдаг.

Эрсдэлийн удирдлага

Занаду компанийн үйл ажиллагаа нь болзошгүй эрсдэлд өртөж байгааг хүлээн зөвшөөрдөг. Удирдлага нь байнгын эрсдэлийн удирдлагыг компанийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг бөгөөд компанийн эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэх чадвар нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хамтын үнэ цэнийг бий болгоход чухал үүрэгтэй.

Занаду эрсдэлийг удирдах болон бууруулах арга барилыг баримталдаг. Эрсдэлийн удирдлагын бодлогыг (ЭУБ) компанийн вэбсайтаас харах боломжтой.

Гүйцэтгэх захирал нь Занадугийн эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хариуцаж, Аудит, эрсдэлийн хороонд тайлагнадаг. Тус хороо эрсдэлийн хяналтыг хариуцаж, эрсдэлийн бүртгэл хөтөлж, зургаан сар тутамд тогтмол хянаж, шинэчилдэг. Тус хороо 2023 оны 3, 9, 12 дугаар саруудад хуралдсан.

Аудит, эрсдэлийн хороо нь хорооны хурал бүрийн дараа Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнадаг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн бүрэлдэхүүн эцсийн дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлоход идэвхтэй оролцдог.

ХАВСРАЛТ 1: ГЛОБАЛ ТАЙЛАГНАЛЫН САНААЧЛАГЫН ИНДЕКС

Мэдэгдэл: Занаду Майнз нь 2023 оны 01 сарын 01-ээс 2023 оны 12 сарын 31-ний хоорондох хугацааны ГТС агуулгын индекс тодорхойлсон мэдээллийг ГТС стандартын дагуу (2021) тайлагнасан болно.

Мэдээлэл

Тайлан дахь байршил

ГТС 1: Тайлангийн суурь 2021

Энэхүү Тогтвортой байдлын тайланг тайлангийн агуулга болон чанарыг тодорхойлох, бодит байдлын үнэлгээ хийх зарчмуудын дагуу бэлтгэсэн болно.

ГТС 2: Ерөнхий мэдээлэл 2021

2-1 Байгууллагын дэлгэрэнгүй	Тайлангийн тухай (хуудас 4) Компанийн тухай (хуудас 9) 2023 оны календарийн жилийн тайлан (хуудас 2)
2-2 Байгууллагын тогтвортой байдлын тайланд багтсан аж ахуйн нэгжүүд	2023 оны календарийн жилийн тайлан (хуудас 78)
2-3 Тайлагналын хугацаа, давтамж болон холбоо барих мэдээлэл	Тайлангийн тухай (хуудас 4)
2-4 Давтан мэдэгдэл	Мэдэгдэл байхгүй
2-5 Гадны баталгаажилт	Үл хамаарах
2-6 Үйл ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээ ба бусад бизнесийн харилцаа	Компанийн тухай (хуудас 9) Төслүүд (хуудас 10)
2-7 Үндсэн ажилчид	Хамт олон (хуудас 22)
2-8 Гэрээт гүйцэтгэгчид	Хамт олон (хуудас 22)
2-9 Засаглалын бүтэц бүрэлдэхүүн	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31), Компанийн Засаглалын Мэдэгдэл 2023
2-10 ТУЗ-ийг Нэр дэвшүүлэх болон Сонгон шалгаруулах	Компанийн Засаглалын Мэдэгдэл 2023, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын Хорооны Дүрэм
2-11 ТУЗ-ийн дарга	Компанийн Засаглалын Мэдэгдэл 2023,
2-12 Нөлөөллийн удирдлагыг хянах ТУЗ-ийн үүрэг	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31), Компанийн Засаглалын Мэдэгдэл 2023
2-13 Нөлөөллийг удирдах үүрэг хариуцлагын хуваарилалт	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31)

Мэдээлэл	Тайлан дахь байршил
2-14 Тогтвортой байдлын тайлан гаргахад ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг	Компанийн Засаглалын Мэдэгдэл 2023
2-15 Ашиг сонирхлын зөрчил	Ёс зүйн дүрэмд ашиг сонирхлын зөрчил хамарна. Бүх ажилтнууд ёс зүйн дүрмийн зөрчлийг (ашиг сонирхлын зөрчил багтана) ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсвэл ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захиралд мэдээллэх шаардлагатай.
2-16 Чухал асуудлуудыг мэдээлэх	Гомдол санал болон чухал асуудлыг Олон нийтийн оролцоо хариуцсан зохицуулагч эсвэл Шүгэл үлээгч ажилтанд мэдэгдэж болно. Үйл ажиллагаа хариуцсан захирал эсвэл Шүгэл үлээгч ажилтан нь эрсдэлийн зэрэглэлд үндэслэн (манай хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд) аливаа чухал асуудлыг хөндөж, Аудит, эрсдэлийн хороонд тайлагнана
2-17 ТУЗ-ийн дэргэдэх хороод	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас 31)
2-18 ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ	ТУЗ-ийн дүрэм ба Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны дүрэм
2-19 Цалин хөлсний бодлого	2023 оны календарийн жилийн тайлан (хуудас 29) Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын Хорооны Дүрэм
2-20 Цалин хөлсийг тодорхойлох үйл явц	2023 оны календарийн жилийн тайлан (хуудас 29)
2-21 Жилийн нийт цалин хөлсийн харьцаа	Боломжгүй. Жилийн нийт цалин хөлсний харьцааг Австрали болон Монгол улсын хууль тогтоомжийн дагуу харьцуулах боломжгүй. Аудит, Эрсдэлийн хороо нь хоёр улсын хэмжээнд цалингийн харьцангуй хамаарлыг мэддэг.
2-22 Тогтвортой хөгжлийн стратегийн мэдэгдэл	Тогтвортой байдлын хандлага (хуудас 13) Тогтвортой байдлын бодлого Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого
2-23 Бодлогын үүрэг хариуцлага	Ёс зүйн дүрэм. Хүний эрхийн бодлого.
2-24 Бодлогын үүрэг хариуцлагуудыг тусгах	Ёс зүйн дүрэм Хүний эрхийн бодлогын Занаду Майнзийн үүрэг хариуцлагууд Ажилтнуудын гарын авлагад багтсан болно.
2-25 Сөрөг нөлөөллийг арилгах үйл явц	Хамтын ажиллагаа (хуудас 26) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)

Мэдээлэл	Тайлан дахь байршил
2-26 Зөвлөгөө авах, асуудал дэвшүүлэх механизм	Сонирхсон асуудлаа илэрхийлэхийн тулд оролцогч талууд Спенсер Коултай +61 2 8280 7497 утсаар эсвэл spencer.cole@xanadumines.com цахим шуудангаар холбогдох боломжтой. Мэдээлэгчийн бодлого
2-27 Хууль тогтоомжийн хэрэгжилт	2023 онд томоохон зөрчил буюу хууль тогтоомж, дүрэм журмын зөрчил гараагүй.
2-28 Гишүүнчлэлийн холбоод	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци Австралийн Худалдааны Танхимын гишүүн
2-29 Оролцогч талуудын оролцооны хандлага	Оролцогч талуудын оролцоо (хуудас 15)
2-30 Хамтын гэрээ хэлэлцээр	Хамтын гэрээнд хамрагдсан ажилтан байхгүй
ГТС 3: Сэдвүүд 2021	
3-1 Материаллаг сэдвүүдийг тодорхойлох үйл явц	Бодит байдал (хуудас 14)
3-2 Материаллаг сэдвүүдийн жагсаалт	Бодит байдал (хуудас 14)
3-3 Материаллаг сэдвүүдийн менежмент	Бодит байдал (хуудас 14)
ГТС 201: Эдийн засгийн гүйцэтгэл 2016	
201-1 Эдийн засгийн шууд үнэ цэнийг бий болгож түгээх	2023 оны календарийн жилийн тайлан
201-2 Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн үр дагавар ба бусад эрсдэл, боломжууд	Мэдээлэл байхгүй
201-3 Тодорхойлсон тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөөний үүрэг хариуцлага болон тэтгэвэрт гарах бусад төлөвлөгөө	Боломжгүй
201-4 Засгийн газраас авсан санхүүгийн тусламж	Засгийн газраас санхүүгийн тусламж дэмжлэг аваагүй
ГТС 203: Эдийн засгийн шууд бус нөлөөлөл 2016	
203-1 Дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба дэмжлэг үзүүлсэн үйлчилгээ	Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт (хуудас 26)
203 -2 Эдийн засгийн шууд бус томоохон нөлөөлөл	Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт (хуудас 26)

Мэдээлэл	Тайлан дахь байршил
ГТС 205 Авлигын эсрэг 2016	
205-1 Авлигын эрсдэлтэй холбоотой үнэлгээ хийгдсэн үйл ажиллагаанууд	Занаду компани Монгол улсад хайгуулын 2 тусгай зөвшөөрлийн талбайтай бөгөөд гол шийдвэрүүд гарах үед уг талбайнууд дээр авлигын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн. Гол шалгуур нь шийдвэр тус бүрийн харьцангуй ач холбогдол, хувийн жин (гэрээний үнийн дүн гэх мэт) дээр үндэслэнэ. Занаду нь Австралид (компанийн хэмжээний) болон Монголд (зөвхөн Монгол дахь үйл ажиллагааны хүрээнд) аудит хийлгэсэн бөгөөд эдгээр аудитыг өөр өөр аудитын компаниуд хийж гүйцэтгэсэн болно.
205-2 Авлигын эсрэг бодлогын мэдээлэл, сургалт	Занаду нь одоо ажиллаж байгаа болон шинэ ажилтнууд, мөн ТУЗ-ийн гишүүдийг Авлига, Хээл Хахуулийн Эсрэг Бодлогын сургалтанд 100% хамрагдсан байхыг шаарддаг ба тус сургалт нь жил бүр явагддаг. Үүнээс гадна Санхүү Эрхэлсэн Захирал жил бүр мэдэгдэл гаргаж үүнийг баталгаажуулдаг
205-3 Авлигын батлагдсан тохиолдлууд болон авсан арга хэмжээнүүд	2023 оны календарийн жилд авилгын зөрчил, тохиолдол гараагүй
ГТС 206 Өрсөлдөөний эсрэг зан төлөв 2016	
206-1 Өрсөлдөөний эсрэг зан төлөв, итгэлийн эсрэг, монополь практикт авах хуулийн арга хэмжээ	2023 оны календарийн жилд хуулийн үйл ажиллагаа явуулсан тохиолдол байхгүй.
ГТС 302: Эрчим хүч	
302-1 Байгууллага доторх эрчим хүчний хэрэглээ	35,255.5 ГЖ
302-2 Байгууллагын гаднах эрчим хүчний хэрэглээ	Мэдээлэл байхгүй
302-3 Эрчим хүчний эрчимжилт	Өрөмдсөн метр тутамд 0.49 ГЖ
302-4 Эрчим хүчний хэрэглээг бууруулах	Боломжгүй
302-5 Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг бууруулах	Боломжгүй
ГТС : 303: Цэвэр ба Бохир ус 2018	
303-1 Усыг хамтын нөөц байдлаар ашиглах	Усны менежмент (хуудас 20)

Мэдээлэл	Тайлан дахь байршил
303-2 Ус зайлуулах шугамтай холбоотой нөлөөллийн менежмент	Зохицуулалтын шаардлагаас хэтэрсэн хамгийн бага стандарт байхгүй.
303-3 Ус татах	Мэдээлэл байхгүй
303-4 Ус зайлуулах	Мэдээлэл байхгүй
303-5 Усны хэрэглээ	Усны менежмент (хуудас 20)
ГТС 304 Биологийн төрөл зүйл 2016	
304-1 Тусгай хамгаалалттай газар нутагт эзэмшиж, түрээсэлж, үйл ажиллагаа явуулж буй талбай болон тусгай хамгаалалттай газар нутгийн гаднах биологийн төрөл зүйлийн өндөр үнэ цэнэ бүхий талбай	Ашиглалтын талбайд тусгай хамгаалалттай газар нутаг, эсвэл биологийн төрөл зүйлийн өндөр үнэ цэнэ бүхий газар байрладаггүй
304-2 Биологийн төрөл зүйлд үзүүлэх үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чухал нөлөө	Газар болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн удирдлага (хуудас 19)
304-3 Хамтгаалалтанд авсан эсвэл нөхөн сэргээсэн орчин	2023 онд Занаду нь хамгаалалт эсвэл нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа шаардлагатай амьдрах орчинд нөлөөлөөгүй
304-4 IUCN-ийн Улаан жагсаалт болон Үндэсний жагсаалтад багтсан төрөл зүйлс	Манай үйл ажиллагаа нь Улаан жагсаалтад багтсан төрөл зүйлс болон үндэсний жагсаалтад багтсан зүйлсэд нөлөөлөөгүй болно.
ГТС 305 Хүлэмжийн хий	
305-1 Шууд (1-р зэрэглэл) Хүлэмжийн хий ялгаруулалт	Уур амьсгалын өөрчлөлт (хуудас 17)
305-2 Эрчим хүч (Шууд бус) (2-р зэрэглэл) Хүлэмжийн хий ялгаруулалт	Уур амьсгалын өөрчлөлт (хуудас 17)
305-3 Бусад шууд бус (3-р зэрэглэлийн) хүлэмжийн хийн ялгарал	Мэдээлэл байхгүй
305-4 Хүлэмжийн хийн ялгаралтын эрчим	Уур амьсгалын өөрчлөлт (хуудас 17)
305-5 Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах	Мэдээлэл байхгүй. Хармагтай төслийн үйл ажиллагаа өсөн нэмэгдэж байгаа нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаас илүүтэй цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдох шаардлага тулгарч байна. ГТС 307: Байгаль орчны нийцэл.
307-1 Байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх	Байгаль орчны менежмент (хуудас 19)

Мэдээлэл	Тайлан дахь байршил
ГТС 401: Хөдөлмөр эрхлэлт 2016	
401-2 Түр болон цагийн ажилтнуудад олгодоггүй үндсэн ажилтнуудад олгодог тэтгэмж	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
401-3 Хүүхэд асрах чөлөө	Ажилтнууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хүүхэд асрах чөлөө авах эрхтэй. 2023 онд хүүхэд асрах чөлөө авсан ажилтан байхгүй.
ГТС 403 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй 2018	
403-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн систем	Занаду нь зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөхийн тулд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын системийг нэвтрүүлсэн.
403-2 Аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ, ослын судалгаа шинжилгээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-3 Хөдөлмөрийн эрүүл ахуйн үйлчилгээ	Боломжгүй
403-4 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар ажилтнуудын оролцоо, зөвлөгөө, харилцаа холбоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-5 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар ажилтнуудын сургалт	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-6 Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-7 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах нь бизнесийн харилцаатай шууд холбоотой	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-8 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд хамрагдсан ажилтнууд	Ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид 100% хамрагдана
403-9 Ажилтай холбоотой осол гэмтэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
403-10 Ажлын байран дахь эрүүл мэнд	2023 онд ажилтай холбоотой эрүүл мэндээрээ хохирсон, нас барсан тохиолдол бүртгэгдээгүй.

Мэдээлэл	Тайлан дахь байршил
ГТС 404 Сургалт, боловсрол 2016	
404-1 Жил бүр нэг ажилтанд ногдох сургалтын дундаж цаг	18.39 цаг
404-2 Ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр, шилжилттэй холбоотой тусламжийн хөтөлбөр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
404-3 Тогтмол гүйцэтгэл болон кареер хөгжлийн хяналтад хамрагдаж буй ажилтнуудын хувь	100%
ГТС 406: Үл ялгаварлан гадуурхах 2016	
406-1 Ялгаварлан гадуурхах тохиолдолд ба засч залруулахаар авсан арга хэмжээ	2023 онд ялгаварлан гадуурхах тохиолдол гараагүй.
ГТС 408: Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 2016	
408-1 Хүүхдийн хөдөлмөрийн осолд эрсдэл ихтэй үйл ажиллагаа ба ханган нийлүүлэгчид	2023 онд тодорхойлсон үйл ажиллагаа болон ханган нийлүүлэгчид байхгүй.
ГТС 409: Албадан хөдөлмөр эрхлэлт 2016	
409-1 Албадан хөдөлмөрийн ослын эрсдэл ихтэй үйл ажиллагаа болон ханган нийлүүлэгчид	2023 онд тодорхойлсон үйл ажиллагаа болон ханган нийлүүлэгчид байхгүй.
ГТС 411: Уугуул иргэдийн эрх ашиг 2016	
411-1 Уугуул иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдлууд	Хамтын ажиллагаа (хуудас 26)
ГТС 413 Орон нутгийн ард иргэд 2016	
413-1 Орон нутгийн ард иргэдийн оролцоог хангах, нөлөөллийн үнэлгээ, хөгжлийн хөтөлбөрүүд	Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт (хуудас 26)
413-2 Орон нутгийн иргэдэд бодитой болон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа	Хамтын ажиллагаа (хуудас 26)
ГТС 415: Төрийн бодлого 2016	
415 -1 Улс төрийн хандив тусламж	2023 онд улс төрийн аливаа хандив тусламж өгөөгүй.

ХАВСРАЛТ 2: ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙ МЕТАЛЛЫН ЗӨВЛӨЛ

Занаду тогтвортой байдлын гүйцэтгэлийн зохих стандартыг Олон Улсын Уул Уурхайн Металлын Зөвлөл (ОУУУМЗ)-ийн Тогтвортой Хөгжлийн Тогтолцооны дагуу байх нь хамгийн сайн практик болно гэж үздэг. Бид ОУУУМЗ-ийн 10 зарчмыг нэвтрүүлэхийг зорин ажиллаж байна. Энэ талаар дараах хүснэгтэд тоймлон үзүүлэв.

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
1-р зарчим Бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагаа, компанийн засаглал, ил тод байдлын зөв тогтолцоог хэрэгжүүлэх	Занаду компанийн ёс зүйн дүрэм болон авлига хээл хахуулийн эсрэг бодлого нь ёс зүйтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэлтийг зохицуулдаг. Компанийн бүх ажилтан сургалтанд хамрагдаж дүрэм журамтай танилцдаг	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31)
2-р зарчим Тогтвортой хөгжлийг компанийн стратеги болон шийдвэр гаргах үйл явцад нэгтгэх.	Занаду нь тогтвортой хөгжлийг шийдвэр гаргалтын үйл явцад нэгтгэн авч үздэг. Тогтвортой байдлын бодлого нь компанийн гол зорилтууд болон үүрэг хариуцлагуудыг тодорхойлсон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хороо нь тогтвортой байдалтай холбоотой асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнадаг.	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31)
3-р зарчим Явуулж буй үйл ажиллагаанаас хамаарч хүн бүрийн хүний эрх, соёл, зан заншил, үнэт зүйлс, ашиг сонирхолыг хүндэтгэх.	Хүний эрхийг эрхэмлэх, соёл, үнэт зүйлсийг хүндэтгэн Занаду компани нь орон нутгийн иргэдийг дэмжиж хамтарч ажиллах, малчин, айл өрхүүдийн усны хангамж, оюутны тэтгэлэгт дэмжлэг үзүүлэх гэх зэрэг төслүүдээр дамжуулан биелүүлдэг	байдал, эрүүл ахуй (хуудас 23) Хамтын ажиллагаа (хуудас 26) Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт (хуудас 26)
4-р зарчим Шинжлэх ухаан, өгөгдөл мэдээлэлд суурилсан эрсдлийн удирдлагын үр дүнтэй стратеги, тогтолцоог хэрэгжүүлэх.	Занаду компанийн Эрсдэлийн удирдлага, Тогтвортой байдлын бодлогын хүрээнд ТҮЗ-ийн доорх Аудит, эрсдлийн дэд хороо нь эрсдлийн удирдлагыг зохицуулан хэрэгжүүлдэг.	Бизнесийн ёс зүй ба ил тод байдал (хуудас. 31)

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
5-р зарчим Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах.	Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартыг Занаду компанийн ТУЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь удирдан хэрэгжүүлдэг.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (хуудас 23)
6-р зарчим Байгаль орчны гүйцэтгэлийн асуудлуудыг тасралтгүй сайжруулахыг эрмэлздэг.	Занаду компанийн ТУЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь байгаль орчны гүйцэтгэлийг компанийн Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартуудын хүрээнд хүрээлэн буй орчинд үлдэх ул мөрийг бууруулахад удирдан хэрэгжүүлдэг.	Байгаль орчны менежмент (хуудас 19)
7-р зарчим Биологийн олон төрөл байдал Байгаль хамгаалахад болон газар ашиглалтын төлөвлөлт, нэгдсэн арга барилд хувь нэмрээ оруулах	Занадугийн ажилчид үйл ажиллагаа явуулж байгаа газраа талбайн байгаль орчны стандартыг дагаж мөрдөх замаар газар нутаг, унаган ургамлыг нь хадгалж амьтны аймаг, түүний нөлөөлөл багасгахыг хичээдэг.	Газар болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн удирдлага (хуудас 19)
8-р зарчим Хариуцлагатай бүтээгдэхүүн боловсруулалт, ашиглалт, дахин ашиглалт, дахин боловсруулалт, устгалтыг дэмжих бий болгох	Занадугийн хамрах хүрээний судалгаа нь, Хармагтай төслийн хөгжилд зориулагдсан аюулгүй байдал болон орчин үеийн шаардлага хангах бүтээгдэхүүн, нөөцийг хамгийн үр ашигтай боловсруулах дахин ашиглах, хог хаягдал үйлдвэрлэл багасгах, хаягдлыг устгах хариуцлагатай үйл ажиллагаа явуулах орчин үеийн үйл ажиллагааны систем технологи боловсруулж байна.	Уур амьсгалын өөрчлөлт (хуудас 17)
9-р зарчим Бидний үйл ажиллагаа явуулж буй нийгэмлэг нийгэмд эдийн засгийн болон институцийн хөгжилд хувь нэмэр оруулах	Занаду олон нийттэй тогтмол хамтран ажиллаж, бат бөх харилцаа тогтоож, нийгэм, эдийн засаг, институцийн ямар боломжууд чухал болохыг ойлгодог. Тус компани нь орон нутгийн иргэдэд бодит үр өгөөж, цаашдын хөгжилд нь урт хугацааны хөгжлийн боломж олгох үүднээс дэмжлэг үзүүлж, хувь нэмрээ оруулдгаараа бахархдаг.	Хамтын ажиллагаа (хуудас 26) Орон нутгийн хөгжил ба хөрөнгө оруулалт (хуудас 26)

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
10-р зарчим Нээлттэй, ил тод байдлаар гол оролцогч талуудыг идэвхтэй оролцуулж, ахиц дэвшил, гүйцэтгэлийг үрдүнтэй тайлагнаж, бие даан шалгах механизмыг бүрдүүлэх.	Тогтвортой байдлын бодлоготойгоо уялдуулан оролцогч талуудтай байнгын хамтын ажиллагаа үүсгэх замаар аюулгүй, эрүүл ажлын нөхцөлийг бий болгож ажилладаг. Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг ойлгосноор бидний бизнес болон орон нутгийн иргэдийн хөгжилд чухал ач холбогдолтой юм.	Оролцогч талуудын оролцоо (хуудас 15)



XANADU MINES

ASX:XAM | TSX:XAM
xanadumines.com